

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ОРОС УЛСЫН ХҮЧИН ЗҮЙЛ

*О.Батсайхан**

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын талаар Үндсэн хуулийн тавдугаар зүйлд заахдаа: “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” хэмээжээ.

“Эдийн засгийн аюулгүй байдал гэж дотоод нөөц бололцоогоо ашиглан нөхөн үйлдвэрлэл явуулах, ард түмнийхээ хэрэгцээг хангах, тусгаар тогтносон байдлаа бэхжүүлэх эдийн засгийн чадавхитай байх, шаардлагатай нөхцөлд улс орноо тодорхой хугацаагаар тэтгэж чадах эдийн засгийн бүтэц бүрдсэн байдлыг хэлнэ” гээд “Эдийн засгийн аюулгүй байдал нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын тулгуур үндэс мөн” хэмээн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 5 дугаар бүлгийн 32 дугаар зүйлд заажээ.

Өнөөгийн олон улсын байдлыг ажиг аваас дэлхийн улс орнуудын харилцан хамаарал, нөлөөлөл, харилцааны цар хүрээ улам ихсэж байгааг төвөггүй харж болно. Харин өндөр хөгжилтэй улс гүрнүүдээс бага буурай улс орнууд хараат байдалд орох хандлага нэмэгдэж байна. Бараг XX зууны турш Монгол Улс геополитикийн байршлаас хамааран их гүрнээс хамаарч ирсэн билээ. Иймээс Монголын үндэсний тусгаар тогтнол, эрх ашигт Оросын хүчин зүйл багагүй нөлөө үзүүлж, эдийн засгийн аюулгүй байдалд өөрийн байр суурийг эзэлж байв.

Монгол Улс 1990 ээд онд хийсэн шинэ сонголт, ардчилал, шинэчлэлийн үрээр өөрийн орны эдийн засаг, нийгэм соёл, газар зүйн байршил, бүс нутгийн орчны онцлог, дэлхийд хийгээд бүс нутагт эзлэх байр сууриа нарийвчлан шинжилсний үр дүнд үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа нэгэнтээ шинэчлэн тодорхойлсон билээ. Энэхүү үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь Үндэсний эдийн засгийг зохицуулах тулгуур үзэл билээ.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үүрэг юуны өмнө Монголын төр засгийн тэргүүн зэргийн үүрэг билээ.

Монгол Улсын төрөөс зах зээлийн эдийн засгийн нөхцөлд иргэдийнхээ эдийн засгийн ашиг сонирхлыг хангах үүднээс үр өгөөжтэй, шударга, тогтвортой эдийн засгийн тогтолцоотой зохицуулалтыг хийх

*О.Батсайхан – ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

учиртай. Гэвч Монголын эдийн засгийн гадаад харилцаа урсгалаар шахам явж буй хэмээн үзнэ. Энд зөвхөн ганцхан жишээ хэлэхэд манай урд хөрш төмөр замаар шалтгаалан нэг хоёрхон хоног хилээ хаахал манай эдийн засгийн байдал ямар байдалд хүрч байсныг бид мэдэх билээ. Дээр нь үндэсний үйлдвэрлэлийн зогсонги байдал, түүний дотор аж үйлдвэрийн боловсруулах салбар уналтанд орж, түүхий эд экспортлогч орон болж хувираад байна. Монголын эдийн засгийн гол салбар болсон мал аж ахуйн бүтээгдэхүүний (малын арьс, шир, ноос) 70 орчим хувь, ямааны ноолуурын 50 гаруй хувийг ямар нэгэн үйлдвэрийн боловсруулалт хийлгүйгээр гадагш буюу ихэвчлэн урд хөршдөө гаргаж байна.(Эдийн засгийн аюулгүй байдал УБ.,2002.,8 дахь тал)

Хүн амын амьжиргааны түвшин эрс ялгаатай болсоор байна. Зарим судлагаагаар хүн амын орлого багатай хэсгийн орлогыг их орлоготой хэсгийнхтэй харьцуулбал 15 дахин доогуур байна гэсэн тооцоо гарчээ. Монголын хүн амын 36 хувь нь ядуурлын түвшинд амьдарч байгаа гэсэн тоо бас бий. Энэ бүхэн Монголын эдийн засгийн бодит байдал ямар байгааг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын эдийн засаг маш сул дорой байна, үүнээсээ хамаараад гадаадын зээл, тусламжинд бүх юмаа даатгаж, ирээдүйд гадны хяналт, хараат байдалд орох нөхцөл бүрдэж байна. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалт үндсэндээ хангалттай хэмжээгээр орж ирэхгүй байна. Жилд 1 тэрбум ам.доллар дунджаар хөрөнгө оруулалтаар орж ирвэл Монгол Улс тун богино хугацаанд хөл дээрээ босож чадна хэмээн би боддог юм. Тэгэхдээ энэ хөрөнгө оруулалтын асуудлыг хамтын хэлбэрээр эргээд төлж чадах салбарт оновчтой үр өгөөжтэй байдлаар зарцуулах хэрэгтэй юм. Эс тэгвээс гадаадынханы амалсан тоо хэрэг дээрээ 50 хувьтай байдаг, өөрөөр хэлбэл бидэнд зээл, тусламж, хөрөнгө оруулалтаар ирж буй үйлдвэрийн тоног төхөөрөмж зах зээлийн үнээсээ 2 дахин илүү үнэтэйгээр тооцогдож явдаг нь нууц биш шүү дээ. Энд Америк, Япон, Хятад, Орос гээд яг адилхан дүрэм үйлчилдэг.

Эдийн засгийн дотоод аюул гэдэг нь өөрийгөө хамгаалах, өөрөө хөгжих чадваргүй байх, төрийн зохицуулалт үр ашиг муутай, янз бүрийн ашиг сонирхлыг уялдуулан зохицуулахгүй аль нэг ашиг сонирхолд хөтлөгдөн нийгмийн хөгжлийн оновчтой зам, чигийг тодорхойлох чадвар сулрахыг хэлнэ хэмээн Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга Н.Баяртсайхан 2002 онд УИХ, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс хамтран зохион байгуулсан «Эдийн засгийн хөгжил,

аюулгүй байдал» бага хурал дээр тавьсан илтгэлдээ тодорхойлоод «судалгаанаас үзвэл Монголын нөхцөлд дотоод аюул давамгайлах хандлага тодорхой илэрч байна. ... манай эдийн засгийн зарим үзүүлэлт нэлээд хэдэн шалгуураар хэвийн хэмжээнээс хэтэрч эдийн засгийн аюулгүй байдал алдагдахад хүрээд байна», «голлох үзүүлэлтүүдээс үзвэл эдийн засгийн аюулгүй байдал эдийн засгийн утгаараа аюултай байдалд хүрчээ» хэмээн дүгнэжээ. Энэ дүгнэлт эдүгээ өөрчлөгдөж дээрдсэн хэмээн би үзэхгүй байна. Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал тийм ч сайнгүй байгаа талаар хүмүүс ам амандаа ярих боловч энэ талаар тодорхой факт, судалгаа хийхээс илэрхий зайлсхийх хандлага ажиглагдаж байна. Энэ бол төрд хүрэх үнэн үг, бодитой судалгаа илт үгүйлэгдэж байгаа хэрэг хэмээн үзэж байна.

Бид эдийн засгийн аюулгүй байдал, түүнд нөлөөлөх гадаад хүчин зүйлс, тухайлбал Оросын хүчин зүйлийн талаар ярихдаа сүүлийн жилүүдэд Монголын төрөөс явуулж буй гадаад бодлогыг сайтар нягтлан үзэх учиртай болов уу.

Манай орны хувьд эдийн засгийн гадаад хүрээнд Орос, Хятад хоёр их хөршийн улс төр, эдийн засгийн гадаад, дотоод бодлого, тэдний нийгмийн тогтвортой байдал, Монголын эдийн засагт нөлөөний хүрээгээ нэгэнтээ тогтоож бэхжүүлж буй ОУВС, дэлхийн болон Азийн банк, олон улсын нөлөө бүхий бусад байгууллагаас цаашид явуулах бодлого тодорхой нөлөө үзүүлж буй нь нэгэнт тодорхой билээ. Өөрөөр хэлбэл Монгол Улс олон улсын зах зээлд ямар орон зай эзэлж, ямар үндэсний бүтээгдэхүүнээр өрсөлдөх, үндэсний валютын ханшны өсөлт бууралт, гадаадаас хөрөнгө оруулалт, тэргүүний технологи оруулах чадавхийг зөв зүйтэй тодорхойлохоос эдийн засаг ихээхэн хамаарах юм.

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал нь улс төрийн аюулгүй байдалтай шууд холбоотой юм. Иймээс Орос Хятадын харилцааны асуудлыг нарийвчлан судлах шаардлагатай байна. Ялангуяа сүүлийн жилүүдэд Оросоос Хятадад цэргийн зэвсэг технологи нийлүүлэх болсонтой холбогдож хоёр талын хооронд нууц гэрээ хэлэлцээрүүд хийгдэж байгаа. XX зууны түүхийн турш Монгол Улс бамбай бүсийн үүрэг гүйцэтгэж ирсэн. Бид энэ үүрэг ролио ч сайн үнэлүүлж чадаагүй, учир нь жижиг орон, тусгаар тогтнолын асуудалтай нягт холбогдолтой учраас тэр. Оросын бодлого Монголын хувьд түүхийн давтамжтай юм шиг хоёрдмол шинжтэй байгаа бөгөөд энэ нь тус бүс нутагт явуулж буй бодлоготой нь холбоотой хэмээн санана. Харин Хятадын бодлого бол ил далд хэлбэрээр ямагт Монголыг өөртөө

нэгтгэх санаа агуулж ирсэн. Бамбай улсын үүрэг Монголын хувьд өмнө нь Зөвлөлт, Хятадын сэргэлдөөнөөр тодорхойлогдож байсан бол одоо Орос, Хятадын хувьд сэргэлдөөн бус стратегийн түншлэлийн нөхцөлд ямар байхыг сайтар нягтлан бодож боловсруулах нь зөв юм. Мэдээж хүйтэн дайны үеийнх шиг бодлого баримталж таарахгүй нь ойлгомжтой, гэхдээ Монголын үндэсний аюулгүй байдлыг Орос, Хятад хоёрын харилцааны уулзвар дээр өөрийн бие даасан байдлаа алдахгүй хэмжээнд авч явах шаардлага бидэнд байгаа юм.

Оросын Монгол дахь ашиг сонирхлын тухай асуудал бол Монголын үндэсний аюулгүй байдалд шууд холбогдох асуудал юм. Оросоос Ази Номхон далайд чиглэсэн бодлогын хүрээнд Монголын талаар явуулж байгаа бодлогыг авч үзэхдээ бид ОХУ-аас өөрийн Сибирь, Алс Дорнотын талаар явуулж байгаа бүс нутгийн бодлоготой нь уялдуулан авч үзэх нь нэн зохимжтой юм. Энэ бүс нутаг дахь ОХУ-ын улс төрийн ашиг сонирхол, улмаар түүнийг дагалдсан бэхжүүлэх үүднээс явагдаж байдаг эдийн засгийн ашиг сонирхлын асуудлыг сайтар судалж, энэ ашиг сонирхол лугаа Монголын үндэсний ашиг сонирхол тодорхой хэмжээгээр харилцан уялдсан байх нь зүйтэй юм. ОХУ-аас Монголыг сонирхох стратеги-улс төрийн болон эдийн засгийн сонирхлын агуулга үндсэндээ өөрчлөгдөөгүй боловч ОХУ-ын төрийн дээд байгууллагаас гаргаж буй баримт бичгүүдэд Монголын талаар бараг дурьдахгүй байгаа бөгөөд зөвхөн ОХУ-ын Засгийн газрын 2002 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн захирамжаар батлагдсан Сибирийн эдийн засгийн хөгжлийн стратеги баримт бичигт “Сибирийн өмнөд хил нь ОХУ-ын улсын хилээр хиллэдэг. Түүнтэй хиллэдэг бүс нутаг нь Хятад, Казахстан, Монголын бүс нутаг бөгөөд тэдгээр нь амьдралын өндөр бүс төвшин, дэд бүтцийн сул хөгжил, байгалийн адил нөхцөлтэй болно. Сибирийн энэ бүс нутгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэхдээ дээрх орнуудтай зөвшилцсөн бодлогоор хэрэгжүүлнэ. Монголтой хилийн хамтын ажиллагааны чухал асуудлууд нь хилийг автомашинаар гарах гарцыг тоноглох, махан бүтээгдэхүүн болон малын гаралтай бүтээгдэхүүн экспортлох, импортлохдоо мал эмнэлгийн хяналтын асуудлыг шийдвэрлэх явдал болно” хэмээн дурьдсан байна. Мөн Сибирь, Алс дорнотын бүс нутгийн талаар ач холбогдол өгч, Байгалийн эдийн засгийн чуулга уулзалтыг хоёр ч удаа амжилттай зохион байгуулаад байна. Тус чуулга уулзалтанд ирүүлсэн ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путиний мэндчилгээнд өгүүлэхдээ: “Та бүхний ажил хэрэгч уулзалт нь энэхүү асар их баялаг бүхий хязгаарын эдийн засгийг хөгжүүлэх стратегийн

зорилтыг хэрэгжүүлэх зам мөрийг хэлэлцэж, Ази Номхон далайн бүс нутгийн улс гүрнүүдтэй харьцах эдийн засгийн холбоо хэлхээнд мэдэгдэхүйц дэм өгөх боломж” хэмээн онцлон тэмдэглэжээ. ОХУ-аас Сибирь болон энэ бүс нутаг, Монголын талаар баримталж байгаа бодлогыг сайтар тандан судалж, энэ бүс нутагт хоёр талын болон олон талын хамтран ажиллах боломжийг үр ашигтай ашиглах талаар санал санаачилгатай ажилламаар байна.

XX зууны эхэн үеэс Монголын тусгаар тогтнолын сэргэлтийн асуудал үндсэндээ Монгол дахь Оросын ашиг сонирхлын асуудалтай, бүр цаашилбал энэ бүс нутаг дахь Оросын нөлөөллийн хүрээнд багтсантай холбоотой явж ирсэн болохыг түүх нотолдог билээ. Энэ хүрээнд Зөвлөлт Орос Улс–Монголын харилцааны удаан хугацааны өвөрмөц хэлбэрээс үүдэж их өрийн асуудал буй болжээ. Энэ асуудал тодорхой хугацаанд Монголын олон нийтийн анхаарлын төвд байж, сая нэгэнт шийдэгдсэн болохоор чухам юунаас шалтгаалж буй болсон хэмээхийг ярих нь илүүц байх. Харин нэгэнт шийдвэрлэгдсэн асуудал нь Монгол Улсын эдийн засгийн хийгээд улс төрийн аюулгүй байдалд эерэг нөлөөлөлтэй байх учиртай хэмээн санана.

Эл асуудал нь зарим талаар нилээд нууцлаг байдалд шийдвэрлэгдсэн мэт сэтгэгдэл төрүүлж байгаа учир нь энэ талаарх эх сурвалжуудын мэдээлэл харилцан адилгүй байна.

Энэ асуудлыг тойрсон элдэв яриа ид өрнөж байгаа үед бидний өнөөдөр ярин буй сэдэвтэй холбоотой, анхаарууштай зарим зүйлийн сэдэв цухалзаж байгааг хэлэх нь зөв байх хэмээн санана. Энэ бол судлаач хүний байр суурь хэмээхийг өчих нь зөв байх. Үүнд: их өрийн асуудлын цаана Монгол дахь Оросын хамтарсан үйлдвэрүүдийн үр ашгийн асуудал яригдаж байгаа, үнэндээ Монголын эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг, төвлөрсөн төсвийн бүрдүүлэлтэнд нөлөөлөх хэмжээний Орос-Монголын хамтарсан Эрдэнэт, Монголросцветмет, УБТЗ зэрэг үйлдвэрийн асуудлыг нухалтай авч үзэх учиртай болов уу. ОХУ-аас сүүлийн жилүүдэд Монголд хамтарсан үйлдвэрийн газар шинээр байгуулаагүй бөгөөд зөвхөн урьдын хамтарсан үйлдвэрүүдийн үр өгөөжийн талаар ярьж байгаа. Уг нь стратегийн зорилтын хүрээнд Монголд хамтарсан үйлдвэр байгуулах хэлбэрээр геополитикийн ашиг сонирхлоо нэмэгдүүлэх бодлого үйл ажиллагаа байж болох юм шиг санагдаж байгаа юм. Гэвч энэ талаар тодорхой алхмууд ОХУ-ын талаас хийгдэхгүй байгаа. Бид ч энэ талаар санаачилга муутай байгаа.

Нөгөө нэг асуудал бол ялангуяа өрийн асуудлыг шийдвэрлэсний дараа Оросын хэвлэлүүдэд Монголын талаар гарч буй зарим нэгэн мэдээ сэлтийг анхаарахгүй байж үл болох мэт. Энэ юу вэ гэвэл, их өрийн асуудлын тухай бичихдээ яагаад ч юм бэ урьд цагт Хятадын нэгэн хэсэг байсан Монгол хэмээх томьёололыг хэрэглэж буй явдал юм. Мэдээж их өрийн асуудлыг шийдвэрлэсэн нь эерэг үр өгөөжтэй байх хэмээн найдавч их өрийн асуудлыг шийдвэрлэсэн Орос улс маань стратегийн хувьд их гүрэн хэвээрээ байгаа, иймээс аливаа асуудалд тэд өөрсдийн байр сууринаас хандсан байхыг үгүйсгэхгүй юм. XX зууны Монгол-Зөвлөлтийн харилцааны түүхэнд билэнд сургамж болохуйц тийм шийдэл гарч байсан шүү. Энд би 1924 оны 5 дугаар сарын 31 ны өдрийн Зөвлөлт, Хятадын гэрээний тавдугаар зүйлийг хэлж байна.

Дараачийн бас нэгэн анхаарлын гадна үлдээж болохгүй асуудал энэхүү өрийн асуудлыг шийдвэрлэхэд Хятад улс оролцсон байж болох талаарх сэжүүр юм. Энэ юу гэсэн үг вэ гэвэл Монголын өрийн асуудлыг Орос, Хятадын харилцааны хүрээний асуудал болгон авч хэлэлцсэн байх вий хэмээх эмзэглэл байгаа юм. Энэ талаар манай сонин хэвлэлүүдэд зарим нэгэн өгүүлэл гарсан билээ.

Экспорт, импортын бүтэц нэг орноос хамаарах нь нэмэгдэх хандлагатай байгаа өнөө үед эдийн засгийн аюулгүй байдлын үүднээс энэ талаар алсын хараатай, төрийн залгамж чанартай нэгдмэл бодлого тууштай хэрэгжүүлэх шаардлагатай байна хэмээн үзэж байна.

Мэдээжийн хэрэг орчин үеийн нөхцөлд эдийн засгийн дангаараа бие даан хөгжих бодлого явуулах нь ухаалаг бус нь ойлгомжтой. Тиймээс Монголын эдийн засгийн бодлого нь дэлхийн улс гүрнүүдийн, түүний дотор Орос, Хятадын бодлоготой харилцан хамааралтай байх нь зүйн хэрэг. Өнөөгийн Монголын эдийн засгийн хөгжлийг авч үзвэл улс орны эдийн засгийн хавсарга болох, хараат байх, стратегийн ач холбогдол бүхий экспортоо алдах аюул Монголын эдийн засгийн аюулгүй байдалд нүүрлэсээр байна.

Монгол Улс өөрийн гадаад бодлогоо тодорхойлж, нэг ёсондоо олон улсын өөрчлөгдөн буй бодит байдалд дасан зохицох, даяаршлын түрэн орж ирж буй урсгалаас үндэсний эдийн засгийн ашиг сонирхлоо хамгаалах талаар зарим нэгэн үйл ажиллагаа явуулж байгаа билээ. Зүүн хойд Азийн бүс нутгийн хөгжлийн асуудлаарх Монголын санал санаачилга, хүчин чармайлт уг нь Монголын эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд нилээд нийцтэй санал байсан бөгөөд үүнийг цаашид хөгжүүлээсэй билээ. Хоёр их гүрний хоёулангийнх нь бүс

нутгийн бодлоготой тэр бүр нийцэхгүй байгаа энэ бүс нутагт Монголын эрх ашиг, сонирхлын бүс байгуулах явдал чухал хэмээн үзэж байна.

Эцсийн эцэст улс орны эдийн засгийн аюулгүй байдал бол дотоод, гадаад орчны хамгийн тааламжгүй үед ч үндэсний ашиг сонирхлоо хамгаалах, нийгэм, улс төрийн тогтвортой байдлыг хадгалж чадах, нийгэмд буй болж мэдэх хямралт байдлаас урьдчилан сэргийлэгдсэн байдлыг хэлэх юм. Чухам үүнд Монголын төрийн эдийн засгийн бодлого нэн даруй чиглэгдсэн байвал зохилтой. Эдийн засгийн аюулгүй байдлын баталгаа нь үндэсний эрх ашиг, сонирхлыг дээдлэх явдалтай шууд холбоотой юм.

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдалд ОХУ-ын хүчин зүйлийг нэмэгдүүлэх үүднээс:

- Оросын Сибирь, Алс Дорнотын асар өргөн зах зээлийг Оростой хамтарсан үйлдвэрийн бүтээгдэхүүнээр хангах замаар хамтран ажиллаж, эдийн засгийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, хамтарсан үйлдвэрийн газрыг шинээр нэмэн байгуулах,

- Уламжлалт сайн хөршийн харилцаандаа тулгуурлан ОХУ-ын Монгол дахь улс төр, эдийн засгийн ашиг сонирхлыг нэмэгдүүлэх талаар санаачлагатай ажиллах, энэ зорилгоор Монгол Улсын Гадаад хэргийн яамны бүтцэд Орос улсыг хариуцсан газрыг бие даалган ажиллуулах,

- Энэ бүс нутагт олон талын хамтын ажиллагааны төсөл хөтөлбөр хамтран боловсруулж, хэрэгжүүлэх, Монголтой ойролцоо байгаль цаг уурын нөхцөлтэй энэ бүс нутгийн олон улсын болон бүсийн төслүүдэд монголын шилдэг залуучуудыг оролцуулах зэрэг саналыг дэвшүүлж байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд холбогдох зарим санаа хэлье.

- Эдүгээ цагийн Монголын төрд үндэсний аюулгүй байдалд аюул учирч буй эсэхийг бодитой тогтоох хэмжүүр тун бүдэг байгаа бөгөөд энэ талаар чухам үнэнийг зоригтой илэрхийлдэг төрийн түшээдээ үгүй хийж, төрд нэг ёсондоо амиа хоохойлогчид олон болсон цаг үе иржээ. Үүнээс үүдэж, чухамхүү аюулгүй байдал хийгээд төрийн бодлогын шинжтэй асуудлаарх алдаа доголдлыг ойлгох чадвар төрд дутмаг болсон хэмээн бодож байна.

- Монголын эх түүхээс сургамж авч, XX зууны Монголын төрийн нэрт зүтгэлтэн А.Амар сайдын айлдсанчлан “дэлхий дахин хэмээхийн өмнө Монгол хэмээн хэлж, гадаадын хэл сурахынхаа өмнө эх болсон монгол хэлээ сайтар эзэмших”-ийн онц чухлыг хэлмээр байна.

- Даяаршил, интеграци гээд олон улсын харилцааны хэв загваруудыг тооцож бодох нь зүйн хэрэг боловч юуны өмнө жижигхэн Монголынхоо үндэсний эрх ашгийг урьтал болгож байхыг сануулсан мэргэн сайдын үгийг сайтар тунгааж үзээсэй хэмээн хүсье.

- Чухамхүү Монголоо хэмээсэн үндэсний үзлээс улс төр, эдийн засгийн аюулгүй байдлын асуудлыг ангид хэмээн ойлгохгүй байна.

- Монголчууд язгуураасаа эрх чөлөөт амьдралд тун дуртай ард түмэн билээ. Тиймээс ч аль нэгэн орны хараат байхыг тэвчдэггүй зантай бөгөөд үүний улмаас XX зуунд гэхэд үндэсний гурван ч хувьсгал гарсан билээ. Эдүгээ ч бидний энд ярьж буй асуудал Оросын хараат байдлаас гарч Хятадын хараат болох вий хэмээсэн эмзэглэлтэй тун холбоотой юм.

- Монголчуудын ойрхи XX зууны түүхээс үзэх аваас үндэсний эрх ашгаа дээдэлж, аюулгүй байдлын бодлогоо Оросын хүчин зүйлтэй холбож ирсэн нь нэгэнт тодорхой бөгөөд цаашид ч Монголын аюулгүй байдлын асуудалд Оросын хүчин зүйл тодорхой байр суурь эзэлсээр байх нь дамжиггүй. Бид энэ талаарх төрийн бодлогоо ул суурьтай хийсэн бодитой судалгаан дээр өөрөөр хэлбэл шинжлэх ухааны үндэслэл дээр тулгуурлан боловсруулж байх нь сөрөг үр дагавар бага авчирна хэмээн бодож байна.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он., УБ., х.6
2. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөл. Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл УБ., 2002 он. х.16
3. Эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал. Монгол Улсын Их Хурал Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хамтран зохион байгуулсан бага хурал 2002 оны 6 дугаар сар., УБ., 2002 он.
4. Байкальский экономический форум 2000 года., 19 – 22 сентября 2000 года., - Вестник Совета Федерации Ио 1, 2001 года., г. Москва.,
5. Резолюция Байкальского экономического форума Аналитический доклад “Стратегия развития России в Азиатско – тихоокеанском регионе в XXI веке”
6. Правительственный документ “Стратегия экономического развития Сибири” - Наука в Сибири, Октябрь 2002 г, Дугаар 39